



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/103/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 262071 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: “Конфиденсе Аудит” ХХК-ийн
Захирал П.Ариунаа
Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



НОГООН НУУР 1008 АЙЛЫН ОРОН
СУУЦ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Д.ОД
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.28 № 07/523
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл нь БНХАУ-ын Засгийн газрын 347.4 сая юанийн буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт 1008 айлын 8 блок орон сууц, авто зогсоол, ногоон байгууламж бүхий цогцолбор хорооллыг 2025 оны 2 дугаар улиралд багтаан дуусгахаар ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн төлөвлөгөөнд үндсэн 3 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 50 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	166,398,391.00	162,036,801.00
31	МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	148,500.00	148,500.00
3121	Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	148,500.00	148,500.00
3122	Банканд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	-	-
34	Урьдчилгаа	138,000,000.00	138,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	138,000,000.00	138,000,000.00
35	Бараа материал	28,249,891.00	23,888,301.00
354	Хангамжийн материал	28,249,891.00	23,888,301.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	246,779,976.92	215,041,030.42
39	Үндсэн хөрөнгө	246,779,976.92	215,041,030.42
392	Биет хөрөнгө	246,235,543.48	214,793,263.62
393	Биет бус хөрөнгө	544,433.44	247,766.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	413,178,367.92	377,077,831.42
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
4144	Урьдчилж орсон орлого	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	413,178,367.92	377,077,831.42
51	Засгийн газрын хувь оролцоо	413,178,367.92	377,077,831.42
512	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	413,178,367.92	413,178,367.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	(36,100,536.50)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ӨМЧИЙН ДҮН	413,178,367.92	377,077,831.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	1,438,833,000.00	9,687,858,452.25
120	Бусад орлого	70,000.00	35,000.00
122	Тусламжийн орлого	-	8,223,363,452.25
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутаг/	1,438,763,000.00	1,464,460,000.00
145006	НӨАТ-ын хөнгөлөлт МУЗГ санхүүжилт	-	-
2	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,810,519,863.01	1,500,595,540.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,810,519,863.01	1,500,595,540.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,662,427,914.17	1,456,240,149.24
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	851,110,716.09	879,662,854.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,367,476.00	108,728,701.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,440,268.07	40,898,011.00
2104	Хангамж бараа материалын зардал	34,943,670.00	28,372,717.68
2105	Нормативт зардал	4,516,750.00	344,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,363,100.00	2,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	563,057,591.00	351,523,029.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,628,343.01	44,360,036.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	148,091,948.84	44,355,390.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(371,686,863.01)	8,187,262,912.20
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	8,223,363,452.25
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(8,223,363,452.25)
5	НИЙТ ҮР ДҮН	(371,686,863.01)	(36,100,540.05)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,438,833,000.00	1,464,495,000.00
120009	Бусад орлого	70,000.00	35,000.00
122	Тусламжийн орлого	1,438,763,000.00	1,464,460,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,438,833,000.00	1,464,495,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,438,833,000.00	1,464,495,000.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,741,051.16	1,420,139,609.19
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	851,110,714.91	879,662,851.19
210101	Үндсэн цалин	851,110,714.91	879,662,851.19
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	105,367,477.18	108,728,700.32
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	71,377,040.12	73,541,475.44
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,511,105.02	8,796,627.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,808,885.28	7,037,302.42
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,936,250.57	1,759,325.90
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	16,734,196.19	17,593,969.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,407,268.07	40,898,011.00
210301	Гэрэл, цахилгаан	13,366,112.07	5,776,811.00
210303	Цэвэр, бохир ус	2,747,000.00	3,810,000.00
210304	Байрны түрээс	32,294,156.00	31,311,200.00
2104	Хангамж бараа материалын зардал	30,993,120.00	26,577,417.68
210401	Бичиг хэрэг	8,366,700.00	6,046,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,600,000.00	2,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,232,330.00	6,805,507.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,772,000.00	1,999,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,022,090.00	8,926,610.00
2105	Норматив зардал	3,227,200.00	344,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,227,200.00	344,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,145,400.00	10,252,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,614,900.00	5,000,000.00
210602	Тавилга	3,218,600.00	3,170,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,311,900.00	2,082,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,797,591.00	349,097,529.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,161,609.00	323,052,187.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	173,982.00	173,982.00
210807	Газрын төлбөр	10,962,000.00	25,871,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,692,280.00	4,577,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,692,280.00	4,577,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	148,091,948.84	44,355,390.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	148,091,948.84	44,355,390.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	148,500.00	148,500.00
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	148,500.00	148,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрийн оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	784,865,203.93	784,865,203.93
2	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(371,686,863.01)	(371,686,863.01)
3	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	413,178,367.92	413,178,367.92
4	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(36,100,536.50)	(36,100,536.50)
5	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	377,077,831.42	377,077,831.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	148,500.00	(148,500.00)	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,464,460,000.00	1,464,495,000.00	(35,000.00)	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,464,460,000.00	1,464,495,000.00	(35,000.00)	100.0
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,464,460,000.00	1,420,139,609.19	44,320,390.81	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	886,015,000.00	879,662,851.19	6,352,148.81	99.3
210101	Цалин, Хөлс	886,015,000.00	879,662,851.19	6,352,148.81	99.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,651,300.00	108,728,700.32	922,599.68	99.2
210201	Тэтгэврийн даатгал	74,462,900.00	73,541,475.44	921,424.56	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,797,100.00	8,796,627.00	473.00	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	7,037,700.00	7,037,302.42	397.58	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,759,400.00	1,759,325.90	74.10	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,594,200.00	17,593,969.56	230.44	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,190,000.00	40,898,011.00	11,291,989.00	78.4
210301	Гэрэл цахилгаан	13,558,000.00	5,776,811.00	7,781,189.00	42.6
210303	Цэвэр, бохир ус	3,898,400.00	3,810,000.00	88,400.00	97.7
210304	Байрны түрээс	34,733,600.00	31,311,200.00	3,422,400.00	90.1
220103	Хангамж, бараа материалын зардал	28,258,100.00	26,577,417.68	1,680,682.32	94.1
210401	Бичиг хэргийн зардал	6,520,000.00	6,046,300.00	473,700.00	92.7
210402	Тээврийн зардал	3,501,600.00	2,800,000.00	701,600.00	80.0

210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр зардал	7,113,000.00	6,805,507.68	307,492.32	95.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	2,120,000.00	1,999,000.00	121,000.00	94.3
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн зүйл	9,003,500.00	8,926,610.00	76,890.00	99.1
22010310	Нормавив зардал	4,280,000.00	344,800.00	3,935,200.00	8.1
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	4,280,000.00	344,800.00	3,935,200.00	8.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,640,000.00	10,252,600.00	6,387,400.00	61.6
210601	Багаж, техник хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210602	Тавилга	5,640,000.00	3,170,600.00	2,469,400.00	56.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	6,000,000.00	2,082,000.00	3,918,000.00	34.7
2107	Томилолт зочны зардал	5,000,000.00	-	5,000,000.00	-
210701	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	-	5,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	357,752,900.00	349,097,529.00	8,655,371.00	97.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	331,538,900.00	323,052,187.00	8,486,713.00	97.4
210804	Тээврийн хэрэгслийн даатгал	174,000.00	173,982.00	18.00	100.0
210807	Газрын төлбөр	26,040,000.00	25,871,360.00	168,640.00	99.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,672,700.00	4,577,700.00	95,000.00	98.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,672,700.00	4,577,700.00	95,000.00	98.0
III	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	44,355,390.81	(44,355,390.81)	-
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,355,390.81	(44,355,390.81)	-
IV	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,464,460,000.00	1,464,495,000.00	(35,000.00)	100.0
	Улсын төсвөөс санхүүжин	1,464,460,000.00	1,464,460,000.00	-	100.0
	Бусад орлого	-	35,000.00	(35,000.00)	-
V	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		148,500.00	(148,500.00)	
VI	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		148,500.00	(148,500.00)	
	АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	-	100.0
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.